

«7 ДУГААР САРЫН 7-Ы ХЭРЭГ ЯВДАЛ» БА ТҮҮНИЙ ТҮҮХЭН СУРГАМЖ

Д. Хүрэлтогоо

Хятадын ард түмний империализм ба колоницлолын эсрэг хийсэн эх оронч, дайчин тэмцлийн түүхэнд «7 дугаар сарын 7-ны хэрэг явдал хэмээн тэмдэглэгдэн орсон тэр нэгэн үйл явдлаас хойш 50 жил өнгөрлөө. 1937 оны 7-р сарын 7-ны өдөр Бээжингээс баруун урагш орший Лу гоуцяо хэмээх гүүрний хавьцаа хээрийн сургууль хийсэн япон цэрэг, оройн 10 цагийн үед хуаран руугаа буцахыг завдан буй байтал уг гүүрний ойролцоо орших Ваньпин хотын зүүн хэсэгт буун дуу гарчээ. Японы цэргийн командлал тэр буун дууг далимдуулан «Японы цэргүүдээс нэг хүн алга болсон, тэр буун дуу, япон цэрэг алга болса явдал хоёр хоорондоо лавтай холбоотой» хэмээн тус хотод орж нэгжлэг хийхийг хот хамгаалж агсан хятад цэргийн талд тулган шаарджээ. Иймд Хятадын нэн шинэ үеийн түүхэнд бас «Лу гоуцяогийн хэрэг явдал» хэмээн нэрлэв. Тэр шаардлагыг үл хүлээн авсан учир Японы цэрэг их буугаар Ваньпин хот ба Лу гоуцяо гүүрийг буудав. Энэ хэрэг явдал чухамдаа нэг талаас империалист Япон Хятадын ард түний эсрэг шууд өдөөн дэгдээсэн колонийн дайн, нөгөө талаас Хятадын ард түмэн эх орноо эзэрхэг түрэмгийчүүдээс чөлөөлөх Японы эсэргүүцсэн дайны эхлэл байсан билээ.

ХКН-ын Төв Хороо 1937 оны 7-р сарын 8-ны өдөр, дээрх хэрэг явдлын тухай мэдээлэл гаргаж улс орноо хамгаалахын тулд эцсийн дусал цусаа хүртэл тулалдан, Японы зандалчдыг Хятад орноос үлдэн гаргахыг бүх эх орон нэгтэндээ уриалсан байна. Тэр өдрөөс хойш ХКН-аар удирдуулсан наймдугаар арми, Шинэ дөрөвдүгээр арми цэрэг, дарга нар японыг эсэргүүцсэн бүх эх оронч хүчний дэмжлэг туслалцаатайгаар эрэлхэг зоригтой тулалдаж 1945 оны 8-р сард эх орноо харийн түрэмгийллээс чөлөөлж, эрх жаргалтай золгох эрин цагийг ойртуулсан юм.

«Жэньминь жибао» сонин «7-р сарын 7-ны хэрэг явдлын» 50 жилийн ойд зориулсан тэргүүн өгүүлэлдээ «Японыг эсэргүүцсэн дайн нь 100 гаруй жилийн турш Хятадын ард түмэн гадаадын түрэмгийлэгчидтэй хийсэн дайнуудаас төгс ялалт байгуулсан анхны дайн юм»¹ гэж тэмдэглэсэн байна. Энэ бол түүхэн үнэн юм. Энэхүү ялалтыг байгуулж чадах болсны үндсэн гол нөхцөл гэвэл марксизм-ленинизмээр зэвсэглэсэн ХКН тэрхүү ширүүн тэмцлийг манлайлах санаачлагыг гартаа авч, дотооддоо эх оронч үзэлтэй бүх анги давхаргыг нэгтгэн чадсан үндэсний нэгдсэн фронтын бодлогыг тууштай хэрэгжүүлэх гадаад талаас олон улсын фашизмын эсрэг тэмцэгч бүх хүчний талархал дэмжлэг, түүний дотор ЗХУ-ын сэтгэл санаа болон биет тусламж дэмжлэгийг авч байсан явдал юм. Ялангуяа Зөвлөлтийн баатарлаг улаан арми, Монголын хувьсгалт цэргийн ангиуд 1945 оны 8-р сар Квантуны армийг бут цохисон явдал Хятадын зүүн хойт нутаг дахь 14 жил үргэлжилсэн японы колонийн дарлал, мөлжлөгийг эцэс болгож, Японы түрэмгийллээс Хятад орныг бүхэлд нь чөлөөлөхөд түүх үүрэг гүйцэтгэсэн билээ.

1 «Жэньминь жибао» 1987. 7.7.

Сүүлийн үед хятадын хэвлэл, удирдах хүмүүс Хятад-Японы найрамдалт харилцаа 1000 жилийн түүхтэй, гэтэл Хятадын эсрэг японы үйлдсэн түрэмгийлэл зуугаадхан жилийн түүхтэй» гэж нэг бус удаа тэмдэглэж байна. Тэгвэл тэрхүү зуун жилийн, сүүлийн 14 жилд (1931-1945) Хятадын ард түмэн Японы фашизмын харгис бурангуй дарлал мөлжлөгт нэрвэгдэж, тэсвэрлэхүйеэ бэрх гаслан зовлон амсан, хэмжээлшгүй гарз хохирол үзсэн юм.

Японыг эсэргүүцсэн дайны 8 жилд (1937.7—1945.8) Хятадын талаас 21 сая хүн алагдаж, шархадсан ба зөвхөн Нанжин (Нанкин) хотод болсон их хядлагын үеэр, хэдхэн хоногийн дотор 300 мянган² энгийн номхон хүний амь насыг бүрэлгэсний дотор найман настай балчир, наян настай хөгшид цөөнгүй байлаа. Я. Накасонэгийн гуравдахь удаагаа эмхлэн байгуулсан (1986 оны 9-р сард) сайд нарын танхимын боловсролын яамны сайд М. Фузио Японы томоохон сэтгүүл «Бунгей сюнью»-н 1986 оны 10-р сарын дугаарт өгсөн интервьудээ Нанжин хотод болсон хядлагын тухай хөндөж, «Хүн алахын тулд дайн хийж байна. Иймд дайнд хүн алахыг аллага гэж үзэхгүй» гэж эрээ цээргүй хэлснээс үзэхэд Японы зарим улс төрийн зүтгэлтнүүд дайн, энхийн асуудалд туйлын хариуцлагагүй хандаж байгаа нь илт байна. Үүнээс гадна 100 млрд. доллартай тэнцэх эд материалын хохиролд өртжээ.³

Японд эзлэгдсэн Хятадын нутгуудаас тоглоомын улс «Маньжоуго» буюу зүүн хойт гурван мужийн ард иргэд хамгийн хүнд зовлонг туулсан юм. Тэндэхийн ард иргэдээс эрэгтэйчүүд нь Квантуны армийн хэрэгцээт цэргийн барилга байгууламжид хүнд хүчир ажил хийж, тэр чигээрээ сураггүй алга болдог байсан бол бие төрсөн бүсгүйчүүд дал мөрөө далдлах ам даавуу ч олддохгүй болтол үгүйрч хоосорсон билээ. Энэ бүхэн бол түүхэн үнэн юм. Гэтэл Японы эрх баригчид тэрхүү байж болшгүй гунигт явдлын зах зухаас нь мартаж эхэлж байх шиг байна. Тэр нь Японы харгис хүчний үйлдэл, тус орны эрх баригчдын болчимгүй байр сууриас үүдэн гарч байгааг хэлэх хэрэгтэй байна. Үүнтэй холбогдуулан зарим нэг баримтыг жишээ болгон дурдъя:

Японы милитаристууд Хятад орныг эзлэн түрэмгийлж байсан бузар явдлыг үгүйсгэж Японы арми Хятад орноор ердөө л орж, гарч байсан мэтээр Японы дунд сургуулийн түүхийн сурах бичигт найруулан оруулах шийдвэрийг 1982 онд Японы Боловсролын яам гаргасан билээ. Энэ нь чухамдаа милитарист Япон Азийн улс түмний эсрэг дэгдээсэн колонийн бузар дайны түүхийг гуйвуулах гэсэн шившигт оролдлого төдийгүй, өнөөдрийн Японы олон нийт, юуны өмнө өнгөрсөн дайны үнэн байдлыг муу мэддэг залуу үеийнхнийг төөрөгдүүлж одоо үед Японд милитаризм дахин сэргэж байгаа осолтой үйл явцыг халхавчлах гэсэн аюултай хандлага юм.

Японд милитаризм сэргэж байгаа нь дэлхий нийтэд илэрхий юм. Ер нь Японы эрх баригч бүлэг тус орны эдийн засгийн өндөр хөгжлийн хүчин чадалд түшиглэн өөрсдийн улс төрийн бодлогыг олон улсын амьдралд аль болохоор нөлөөлүүлэхийг оролдож байгаа төдийгүй, тус орны цэргийн хүчин чадлыг байнга нэмэгдүүлж байна. Японы засгийн газар цэргийн зардлыг үндэсний орлогын нэг хувиас хэтрүүлж болох шийдвэр гаргасан нь зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг чөлөөтэй болгон Япон улсыг дахин милитаристчилах замыг нээж байгаа хэрэг

2 «Жэньминь жибао» сонин, 1987.7.8.

3 «Жэньминьжибао» сонин -" - 1987. 7. 7

юм. Зөвхөн 1987 он гэхэд Япон улс цэргийн хэрэгцээнд 25 млрд доллар зарцуулах ажээ⁴.

Япон нь АНУ-ын Алс Дорнод дахь цэргийн гол түнш бөгөөд Вашингтоны төлөвлөж байгаа «Оддын дайны» бэлтгэлд оролцогч гол орон болоод байна. Саяхан Японы засгийн газар АНУ-ын «стратегийн батлан хамгаалалтын санаачлага» хэмээх программд Японы фирмүүд оролцох нөхцөл болзлын тухай Япон-Америкийн хэлэлцээрийн төслийг баталсан байна. Одоогийн байдлаар Японы 20 гаруй фирм «Оддын дайны» бэлтгэлд оролцох захиалга өгөөд байна. Япон уг ажилд оролцоноор түүний байлдааны зэвсэг техник үйлдвэрлэх арга ажиллагаа улам боловсронгуй болж, зэвсгээр хөөцөлдөх хүч чадал нь улам нэмэгдэх юм. Иймд энэ нь туйлын осолтой хэрэг бөгөөд Ази, ялангуяа Алс дорнотын олон улсын байдлыг улам хурцатгаж байна. Гэвч өнгөрсөн дайны гайгамшигийг биеэр амсаж, хүн төрөлхтний түүхэнд эн түрүү цөмийн хөнөөлд өртсөн Японы ард түмэн, янз бүрийн давхаргааны дэвшилт үзэлтэй хүмүүс Японы засгийн газрын энэхүү осолтой алхамыг хүчтэй эсэргүүцэж байна. Жишээ нь, Японы улсын байгууллагын 3500 эрдэм шинжилгээний ажилтнуудаас санал хураахад тэдний 79 хувь нь Япон СОИ-д оролцохыг эсэргүүцэж мөн 73 хувь нь «Оддын дайны» программын дагуу судалгааны ажилд оролцохоос татгалзах бодолтой байгаагаа илэрхийлжээ⁵.

Хятад-Японы харилцаанд гарсан өөр нэг ноцтой, эвгүй явдал гэвэл Японы ерөнхий сайд Я. Накасонэ «Ясукуни Жинжя» хэмээх сүмд очиж (1983, 1985 онд) албан тушаалд байгаа засгийн тэргүүний хувьд, мөргөл ёслол үйлдсэн явдал юм. Тэрхүү сүмийг анх 1869 онд японы Мэйжи хааны зарлигаар «Токио сё кон ся» (сүнс мөр даатгах сүм гэсэн утгатай. -Д.Х) хэмээх нэртэйгээр байгуулж, 1879 оноос одоогийн нэрийг хэрэглэх болов. Дэлхийн II дайн дуусахаас өмнө Японд бусад сүмийг дотоод явдлын Яам нь харъяалан захирдаг байсан байхад «Ясукуни жинжя»-г Японы хуурай замын цэргийн яам, Далайн цэргийн яам хамтран харъяалж, Японы милитаристуудаас Азийн улс түмний эсрэг өдөөсөн бузар дайнд алагдсан цэрэг, дарга нарт Японы ерөнхий сайд Я. Накасонэ «Ясүкүни жинжя» хэмээх сүмд Тозио тэргүүтэй Японы «А» группийн цэргийн гол гэмт хэрэгтэн нарын нэр ч байна. Учир иймд ерөнхий сайд Я. Накасонэ тийм сүмд очиж гашуудлын ёслол үйлдсэн нь БНХАУ-ын хэвлэлд бичиж байгаагаар «Хятадын ард түмний сэтгэл санааг хөндөж эмзэглүүлсэн хэрэг» төдий биш, Японы түрэмгийлэлд хэлмэгдсэн бүх орны ард түмнийг үл тоомсорлосон хэрэг юм. Нөгөөтэйгүүр Японы ерөнхий сайдын тэрхүү зүйд үл нийцэх үйлдэл нь Японыг дахин милитарист замд татан оруулахыг санаархаж байгаа харгис хүчний элдэв оролдлогыг өөгшүүлэхэд хүргэсэн байна.

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн их гай гамшиг тарьсан дэлхийн II дайн юугаар төгссөнийг түүх бэлхнээ нотолсоор байхад Японы өнөөгийн эрх баригчид цөмийн эрин үед өөрийн орныг дахин милитаристчлах зам руу түлхэн оруулах нь юутай аюултай болохыг хэлэхийг хэрэг юун ажээ. Одоогоос 40 гаруй жилийн өмнөх тэрхүү түүхэн сургамжийг мартаж эрх хэнд ч байхгүй юм.

4 «Правда» 1987.8.7.

5 «Правда» 1987.7.23.

Тун саяхан Хятад-Японы харилцаанд гарсан бас нэг зохисгүй явдал гэвэл Японы Осака хотын дээд шүүх 1987 оны 2-р сарын «Гуанхуа Ляо» хэмээх байрыг «Дундад иргэн улсын» (Тайвань) мэдлийн хөрөнгө мөн гэсэн шийдвэр гаргажээ.* Энэ нь үнэн хэрэг дээрээ Японы эрх баригчид «Хоёр Хятад» эсвэл «Нэг Хятад нэг Тайвань» байдаг гэсэн урьдын улиг домог болсон байр сууриа бүрмөсөн орхиогүйн баримт мөн билээ. 1972 оны 9-р сард Хятад, Япон хоёр улсын Гадаад явдлын Яамдын сайдууд гарын үсэг зурсан Хятад-Японы хамтарсан мэдэгдэлд «Япон улсын засгийн газар БНХАУ-ын засгийн газрыг Хятадын цорын ганц хууль ёсны засгийн газар хэмээн хүлээн зөвшөөрнө» гэж бэлээхэн тэмдэглэсэн атал Японы хуулийн байгууллага тийм шийдвэр гаргасан явдал нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцэхгүй нь мэдээж хэрэг мөн.

ХКН-ын Зөвлөхүүдийн Төв комиссын дарга Дэн Сяопин 1987 оны 6-р сарын 4-нд Японы Комейто намын дарга Яно тэргүүтэй тус намын төлөөлөгчидтэй ярилцахдаа «Хятад, Япон хоёр цаашид найрсаг биш байх ямар ч шалтгаангүй юм» гээд «Хятад-Японы хоорондох маргаантай асуудлуудад хоёр орны улс төрийн зүтгэлтнүүд хоёр орны найрамдалт харилцаа түүний дотор улс төр, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх үүднээс хандах ёстой»⁶ гэж их л найдвар тавьсан мэдэгдэл хийж байхад Японы Гадаад явдлын яамны өндөр албан тушаал тан Дэн Сяопинг «Япон-Хятадын харилцааны бодит байдлыг олж барихгүй байна» гээд түүнийг «Хятадын нэгдмэл санаа бодлыг төлөөлөхгүй»⁷ гэж мэдэгдсэн байна. Хятад-Японы харилцаанд гарч байгаа дээрх маргаантай асуудлуудын талаар Японы тал хэдийгээр иймэрхүү хүйтэвтэр байр суурьтай байгаа боловч БНХАУ уг маргааныг цаашид гүнзгийрүүлэхгүйг хичээж байгаа нь Японыг эсэргүүцсэн дайн эхэлсний 50 жилийн ойд зориулж Хятадын сонин хэвлэлд нийтэлсэн олон тооны өгүүлэл дурдатгалаас ажиглагдаж байна. Ойд зориулж Хятадын хотуудад эрдэм шинжилгээний бага хурал, том жижиг дурсгалын цуглаан зохиогдож, мөн Бээжинд дайны дурсгалын музей байгуулжээ.

Уг ойд зориулж Бээжинд болсон БНХАУ-ын нам төрийн удирдагчид оролцсон цуглаан дээр Хятадын Нийгмийн шинжлэх ухааны Академийн ерөнхийлөгч Ху Шэн хэлсэн үгэндээ хоёр орны найрсаг - хамтын ажиллагааг Хятад-Японы хооронд байгуулсан гэрээ хэлэлцээр болон хэлэлцэн тохирсон зарчмын үндсэн дээр хөгжүүлэх нь«. . . Ази, Номхон далайн районы энх тайвныг сахин хамгаалахад бас ашигтай» гэж тэмдэглэсэн байна. Үүнтэй холбогдуулан хэлэхэд Ази-Номхон далайн бүс нутагт хамаарагдах улс орнуудын гадаад улс төрийн бодлого, тэдний хоорондын харилцаа ямар байхаас манай гаригийн энэ хэсгийн олон улсын байдал шалтгаалах зүйл цөөнгүй юм. Учир иймд Хятад-Японы харилцаа олон улсын практикт нэвтэрсэн зарчим, хэм хэмжээний үндсэн дээр хэвийн байх явдал чухал болох нь мэдээж хэрэг юм. Харамсалтай нь тус хоёр орны харилцаа хараахан бас тийм биш байна.

* Дэлхийн II дайны дараа гоминданыхан Японы түрэмгий цэрэг Хятадаас тонон дээрэмдэж аваачсан эд агуурсыг эргүүлэн авч борлуулж олсон мөнгөөр нэгэн байшин худалдан авч, түүнийг «Гуанхуа-Ляо» хэмээн нэрлэн Японд суралцдаг хятад оюутнуудыг байрлуулж байжээ. БНХАУ ба Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосны дараа БНХАУ-аас Японд суугаа байгууллагууд уг байрыг эзэмших болов.

6 «Жэньминь жибао» 1987.6.5.

7 «Жэньминь жибао» 1987.6.8.

ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ху Цяому «Жэньминь жибао» сонинд Нийтлүүлсэн «8 жилийн эсэргүүцлийн дайны агуу их түүхэн ач холбогдлыг товч өгүүлэх нь» хэмээх өгүүлэлдээ «...Японы эрх баригчид одоо хүртэл томоохон чухал асуудлууд дээр аанай л зөвхөн үг яриан дээр болохоос биш тодорхой үйл ажиллагаан дээрээ Хятад-Японы хамтарсан мэдэгдэл ба Хятад-Японы энх тайван, найрамдлын гэрээний зарчмуудыг дорвитой хэрэгжүүлэхгүй байна»⁸ гэжээ. Хятад-Японы харилцааны дээр хөндөгдсөн баримт бичгүүдийн тодорхой зүйлүүдийг японы тал татгалзангүй байж гарын үсэг зурсныг нь тэдгээрийн тухай хоёр талын хийсэн хэлэлцээний явц харуулж байв.

Японы гадаад дотоод бодлогыг БНХАУ зарим талаар бодитойгоор үнэлэх явдал харагдах боллоо. ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, НТХ-ны Цэргийн Зөвлөлийн орлогч дарга Ян Шан кунь Японыг эсэргүүцсэн дайны дурсгалын музейн нээлтийн цуглаан Дээр хэлсэн үгэндээ «. . .Японы милитаристуудын үйлдсэн түүхэн гунигт явдлыг дахин хэрхэвч гаргуулахгүй»⁹ гэж хэлсэн ба Ху Цяому дээр дурдсан өгүүлэлдээ Японы цэргийн зардлыг үндэсний нийт орлогын нэг хувиас хэтрүүлэн зарцуулах болсонд «Азийн зэргэлдээ орнууд сэтгэл түгшиж» байгаа тухай тэмдэглэсэн зэргээс үзвэл Японд милитаризм сэргэж байгаа ба түүний аюул заналыг Хятадын удирдлага мэдэрч эхэлж байх шиг байна. Ху Цяому өөрийн өгүүллийн төгсгөлд Кунзын сургаалаас «Хүнд хандахдаа түүний үгийг сонсохын зэрэгцээ үйлсийг нь харах хэрэгтэй» гэсэн байдгийг иш татаж «Японы засгийн газар хаашаа явахыг бид ширтэн хүлээх болно» гэсэн байна.

Хятадын удирдагчид «Хятад-Япон хоёр улс үеийн үед найрамдалтай байх болно» гэсэн бодлогоо «тууштай баримтлахын» зэрэгцээ Японы удирдагчид зөвхөн Хятад-Японы харилцааны хувьд биш дайн, энхийн асуудлын хувьд ч хаашаа явахыг нь сайтар ажиглах нь зүйтэй мэт санагдаж байна.

8 «Жэньминь жибао» 1987.7.8.

9 «Жэньминь жибао» 1987.7.7.